



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1108

Улаанбаатар хот

Г Б.Эрдэнэбатад чөлөө, тэтгэмж олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн Иргэдийн өргөдөл, эрэлт хүсэлт, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Бямбаагийн Эрдэнэбатын төрсөн охин нас барсан тул албаны дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.19.2, 8 дугаар зүйлийн 8.8.1-д заасны дагуу 2019 оны 01 дүгээр сарын 15-аас 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд цалинтай чөлөө, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж тус тус олгосугай.

2. Б.Эрдэнэбатад олгох 640.000 /зургаан зуун дөчин мянга/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

